



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### ХХVIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын ХХVIII хурал 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 10:00 цагт Төрийн ордны Шадар сайдын өрөөнд 80 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалав.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар;

Онцгой байдлын өрөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын орлогч дарга,  
бригадын генерал Г.Ариунбуян

2. Улаанбаатар хотын олон улсын нисэх буудлыг ашиглалтанд оруулахад шаардлагатай шалгалтын нислэгийг зохион байгуулах тухай;

Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн  
Л.Халтар

3. Дорнод аймгийн Халх гол сумын Сүмбэр-Рашаан хилийн авто замын боомтыг нээх эсэх тухай;

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн  
Н.Анхбаяр

4. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

А. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал сунгах, энэ асуудлаар хилийн боомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр тогтов.

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,

бригадын генерал, Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандaa Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга нарт:

1.1. “Чингис хаан” болон “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын “Хэрэглэлээр буулт үйлдэх систем”-ийн шалгалтын нислэгийг БНХАУ-ын Иргэний нисэхийн удирдах газрын Шалгалтын нислэгийн төвийн 5 /таван/ хүний бүрэлдэхүүнтэй багаар гүйцэтгүүлэх асуудлыг 2020 оны 9 дүгээр сарын гуравдугаар арав хоногт зохион байгуулах;

1.2. Шалгалтын нислэгийг зохион байгуулахдаа халдварт, хамгаалалтын дэглэмийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагууд болон Улсын онцгой комиссын Шуурхай штабтай хамтран гаргах;

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандын Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга нарт:

2.1. Монгол, Хятадын хилийн Сүмбэр-Рашаан боомтыг нээн ажиллуулах талаар хятадын талтай дипломат шугамаар тохиролцох;

2.2 Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тал зөвшөөрвөл Монгол, Хятадын хилийн олон улсын зэрэглэлтэй, түр ажиллагаатай Сүмбэр-Рашаан боомтыг нээн ажиллуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

Гурав. Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр,

Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуюн,

Зэвсэгт хучний Жанжин штабын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Д.Ганзориг нарт:

3.1. “Кавказ-2020” Стратегийн команд штабын сургуулийн нээлтэд хүндэт зочноор уригдсан Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярыг оролцуулах боломжгүй талаар ОХУ-ын талд дипломат шугамаар мэдэгдэх;

3.2. Оросын Холбооны Улсад болох “Кавказ-2020” хээрийн сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчинээс бие бүрэлдэхүүн (оролцуулах боломжгүй талаар ОХУ-ын талтай дипломат шугамаар мэдэгдэх)

3.3. Оросын Холбооны Улстай явуулах “Сэлэнгэ-2020” хоёр талын хамтарсан сургуулийн Команд-штабын сургуулийг цахим хэлбэрээр, Монгол Улсын Зэвсэгт хучний мотобуудлагын батальоны байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг өөрийн нутаг дэвсгэр дээр зохион байгуулах боломжийн талаар судалж ОХУ-ын талтай тохиролцох.

3.4. “Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монголын цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг сургах болон “Уулын явган цэргийн сургалт”-ыг зохион байгуулах, чадавхыг нэмэгдүүлэхээр Монгол Улсад үүрэг гүйцэтгэх Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 80 цэргийн алба хаагчийг хүлээн авах, тусгаарлах (тусгаарлалтыг тогтсон горимын дагуу 21 хоногоор зохион байгуулах) ажиллагааг зохион байгуулах;

Дөрөв. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт:

4.1. Гамшгийн онцгой нөхцөл үүссэнтэй холбогдуулан КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гарсан тогтоол, шийдвэр, дүрэм, журам, дэглэмийн хүрээнд олон улсын айлчлалыг Монгол Улсад зохион байгуулах тухай түр журам боловсруулж, Улсын онцгой комиссын даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулах;

ДАРГА,  
ШАДАР САЙД



Я.СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.САНЖАА